

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ
ШҮҮХИЙН СУДАЛГАА, МЭДЭЭЛЭЛ, СУРГАЛТЫН ТӨВ

**АВЛИГЫН ХЭРГИЙН ДАГНАСАН ШҮҮХ БАЙГУУЛАХ
ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ
СУДАЛГААНЫ ТАЙЛАН**



Улаанбаатар хот
2021 он


АГУУЛГА

НЭГ. АВЛИГЫН ХЭРГИЙГ ШҮҮХЭЭР ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ	2
ХОЁР. АВЛИГЫН ХЭРГИЙН ДАГНАСАН ШҮҮХТЭЙ ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ТУРШЛАГА	9
ГУРАВ. АВЛГЫН ХЭРГИЙГ ШҮҮХЭЭС ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ	22
ДӨРӨВ. АВЛГЫН ХЭРГИЙГ ШҮҮХЭЭС ҮР НӨЛӨӨТЭЙ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ	24
ТАВ. АВЛИГЫН ХЭРГИЙН ДАГНАСАН ШҮҮХ БАЙГУУЛСНААР БИЙ БОЛОХ ДАВУУ, СУЛ ТАЛ БОЛОН БОЛОМЖ ЭРСДЭЛ (SWOT ШИНЖИЛГЭЭ)	28
ЗУРГАА. АВЛГЫН ХЭРГИЙГ ШҮҮХЭЭС ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ҮР НӨЛӨӨТЭЙ ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЭХ САНАЛ, ХУВИЛБАР	29
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	30



НЭГ. АВЛИГЫН ХЭРГИЙГ ШҮҮХЭЭР ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

График 1. Авлигын хэргийн шүүхээр хянан шийдвэрлэсэн байдал, сүүлийн 10 жилээр




2011-2020 оны хооронд Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх нийт 85386 эрүүгийн хэрэг шийдвэрлэснээс 407 буюу 0.48% нь авлигын хэрэг байна. Мөн онуудад давж заалдах шатны шүүхээр 21239 эрүүгийн хэрэг шийдвэрлэснээс 395 буюу 1.86% нь авлигын хэрэг байгаа бол хяналтын шатны шүүх 7469 эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэснээс 129 буюу 1.73% нь авлигын хэрэг байна. Эндээс үзвэл авлигын хэрэг нь дараагийн шатны шүүхэд хандах байдал өндөр буюу анхан шатны шүүхээс шийдвэрлэсэн хэргийн 97% нь давж заалдах шатны шүүхэд хандсан бол үүнээс 33 хувь нь хяналтын шатны шүүхэд хандсан байна.

Хүснэгт 1. Шүүхээр хянан шийдвэрлэсэн авлигын хэрэг, сүүлийн 10 жилээр

Он	Анхан шатны шүүх			Давж заалдах шатны шүүх			Хяналтын шатны шүүх		
	Нийт эрүүгийн хэрэг	Үүнээс: Авлигын хэрэг	Эзлэх хувь	Нийт эрүүгийн хэрэг	Үүнээс: Авлигын хэрэг	Эзлэх хувь	Нийт эрүүгийн хэрэг	Үүнээс: Авлигын хэрэг	Эзлэх хувь
2011	5877	6	0.10%	2032	13	0.64%	807	0	0.00%
2012	6161	10	0.16%	2168	18	0.83%	859	9	1.05%
2013	6169	17	0.28%	1960	1	0.05%	685	0	0.00%
2014	6375	35	0.55%	2161	72	3.33%	629	18	2.86%
2015	6756	22	0.33%	1971	25	1.27%	520	5	0.96%
2016	5762	22	0.38%	1822	29	1.59%	454	10	2.20%
2017	8839	33	0.37%	1971	76	3.86%	466	13	2.79%
2018	12551	58	0.46%	2166	22	1.02%	861	23	2.67%
2019	13427	88	0.66%	2286	57	2.49%	971	20	2.06%
2020	13469	116	0.86%	2702	82	3.03%	1217	31	2.55%
Нийт	85386	407	0.48%	21239	395	1.86%	7469	129	1.73%
Дундаж	8539	41	0.05%	2124	40	0.19%	747	13	0.17%


2011-2020 онуудад Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн нийт шийдвэрлэсэн хэргийн 0.1-0.66 хувийг авлигын хэрэг эзэлж байсан бол давж заалдах шатны шүүхийн хувьд 0.05-3.86 хувийг, хяналтын шатны шүүхийн шийдвэрлэсэн хэргийн 0.96-2.86 хувийг тус тус авлигын хэрэг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дундажаар анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэрэгт авлигын гэмт хэргийн эзлэх хувь хэмжээ дараагийн шатны шүүхүүдээс 0.1 хувиар бага байна. Мөн сүүлийн жилүүдэд авлигын гэмт хэрэг эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх болон хяналтын шатны шүүхийн нийт шийдвэрлэсэн хэргийн 2-3 хувийг эзлэх болж, энэ төрлийн хэрэг маргааны өсөлт нь тусгай шүүх байгуулах, мэргэшсэн шүүгч ажиллуулах зэргээр тухайн төрлийн хэргийг анхааран судлах хэрэгцээ шаардлага бий болсныг харуулж байна.

График 2. Анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн авлигын гэмт хэрэг, өсөлт бууралтын хувиар, 2011-2020 он




Сүүлийн 10 жилийн хугацаанд анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн авлигын гэмт хэргийн тоо 2015, 2016 оноос бусад онд тогтмол өсөлттэй буюу өмнөх оноосоо 32-106 хүртэл хувийн өсөлттэй байжээ. Мөн 2011 онд 6 авлигын хэрэг шийдвэрлэж байсан бол 2020 онд 116 авлигын хэрэг шийдвэрлэсэн нь 19.3 дахин өссөн үзүүлэлт юм.

График 3. Давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэсэн авлигын гэмт хэрэг, өсөлт бууралтын хувиар, 2011-2020 он




Сүүлийн 10 жилийн хугацаанд давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэсэн авлигын гэмт хэрэг 2013, 2015 оноос бусад онд тогтмол өсөлттэй буюу өмнөх оноосоо 16-7100 хүртэл хувийн өсөлттэй байжээ. Мөн 2011 онд 13 авлигын хэрэг шийдвэрлэж байсан бол 2020 онд 80 авлигын хэрэг шийдвэрлэсэн нь 6.1 дахин өссөн үзүүлэлт юм.

График 4. Хяналтын шатны шүүхээр шийдвэрлэсэн авлигын гэмт хэрэг, өсөлт бууралтын хувиар, 2011-2020 он



Сүүлийн 10 жилийн хугацаанд хяналтын шатны шүүхээр шийдвэрлэсэн авлигын гэмт хэрэг 2013, 2015, 2019 оноос бусад онд тогтмол өсөлттэй буюу өмнөх оноосоо 56-200 хүртэл хувийн өсөлттэй байжээ. Мөн 2011 онд хяналтын шатны шүүх авлигын хэрэг буюу 2002 оны Эрүүгийн хуулиар хэрэг шийдвэрлэж байгаагүй бол 2020 онд 31 авлигын хэрэг шийдвэрлэсэн байна.


График 5. Авлигын гэмт хэргийг шийдвэрлэсэн зүйл, 2002 оны болон 2015 оны Эрүүгийн хуулиар, 2011-2020 оны нийт дүнгээр



Сүүлийн 10 жилд авлигын хэрэг шийдвэрлэсэн байдлыг аваад үзвэл 2017 он хүртэл 2002 оны Эрүүгийн хуулийн 263-273 дугаар зүйл, 2017 оноос хойш 2015 оны Эрүүгийн хуулийн


22 дугаар бүлгээр тус тус зүйлчилсэн байна. Тухайн хугацаанд Анхан шатны шүүхээс 2015 оны Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйл болон 22.4 дүгээр зүйлийг үндэслэн шийтгэх тогтоол бичсэн байдал өндөр байгаа бол давж заалдах шатны шүүх болон хяналтын шатны шүүхийн хувьд 2002 оны Эрүүгийн хуулийн 268, 269 дүгээр зүйлийг үндэслэсэн шийтгэх тогтоол бичсэн байдал хамгийн олон байна.

График 6. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, журмаар, Анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн авлигын хэрэг, 2018-2020 оноор




2020 онд Анхан шатны шүүх 116 авлигын хэрэг хянан шийдвэрлэсэн ба үүнээс 16 буюу 13.8% хувь нь, 2019 онд 2 буюу 4.3% нь, 2018 онд 2 буюу 7.1% нь тус тус хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдсэн байна.

График 7. Шүүх бүрэлдэхүүн, Анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн авлигын хэрэг, 2018-2020 оноор




2018 болон 2019 онд Анхан шатны шүүхээр авлигын гэмт хэргийг шүүх бүрэлдэхүүн дангаар шийдвэрлэсэн байдал 100% байгаа бол 2020 онд шийдвэрлэсэн авлигын хэргийн 1 буюу 0.9% нь бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэгдсэн байна.

График 8. Өмгөөлөгч оролцсон шүүх хурал, Анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн авлигын хэрэг, 2018-2020 оноор



Анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн авлигын хэргийн шүүх хуралд 2020 онд 111 буюу 96% нь, 2019 онд 36 буюу 77% нь, 2018 онд 35 буюу 100% өмгөөлөгч оролцсон байна.

График 9. Ял шийтгүүлсэн хүн, Анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн авлигын хэрэг, 2018-2020 оноор



2020 онд анхан шатны шүүхээр 198 хүн авлигын хэргээр ял шийтгүүлсэн ба үүнээс 157 буюу 79% нь торгох ялаар шийтгүүлсэн бол 41 буюу 21% нь хорих ял шийтгүүлсэн байна. Харин 2019 онд 85 хүн авлигын хэргээр ял шийтгүүлснээс 70 буюу 82% нь торгох ялаар, 15 буюу 18% нь хорих ял шийтгүүлсэн байна. Эндээс үзвэл 2020 онд ял шийтгүүлсэн хүний тоо 2019 оноос 1.3 дахин өссөн бөгөөд хорих ял шийтгүүлсэн хувь хэмжээ 3%-иар өссөн байна.

График 10. Торгуулийн мөнгөн дүн, Анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн авлигын хэрэг, 2018-2020 оноор





График 10-ийг харвал Анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн авлигын хэргийн тоо өсч буйтай холбоотойгоор торгох ял шийтгүүлсэн хүний тоо болон торгуулийн мөнгөн дүн шууд хамааралтайгаар өсч байна. Тухайлбал 2018 онд 281,600,000 төгрөгийн торгуулийн мөнгөн дүн бүртгэгдсэн бол 2020 онд 1,341,152,000 төгрөг болж 4.7 дахин өссөн байна.


График 11. Авлигын хэргээр шүүхээс тогтоосон албадлагын арга хэмжээний төрөл, биелэлт, 2021 оны эхний 3 улирлын байдлаар



Эх сурвалж: ШШГЕГ, Албадлагын арга хэмжээ, хяналтын хэлтэс

2021 оны 3 дугаар улирлын байдлаар Авлигын хэргийн шүүхийн шийдвэрийн биелэлтийг авч үзэхэд тэнссэн албадлагын арга хэмжээ 46%-ийн, хугацааны өмнө тэнсэн суллагдсаг 55%-ийн, ял хойшлуулсан албадлагын арга хэмжээ 25%-ийн, хөрөнгө орлого хураах албадлагын арга хэмжээ 32%-ийн биелэлттэй байна. Авлигын хэргээр шүүхээс тогтоосон албадлагын арга хэмжээний биелэлтийг нэгтгэн авч үзвэл 44.7%-ийн биелэлттэй байна.

График 12. Авлигын хэргээр шүүхээс тогтоосон ялын төрөл, биелэлт, 2021 оны эхний 3 улирлын байдлаар



Эх сурвалж: ШШГЕГ, Хорихоос өөр төрлийн ялын бүртгэл хяналтын хэлтэс

2021 оны 3 дугаар улирлын байдлаар Авлигын хэргээр шүүхээс тогтоосон ялын биелэлтийг авч үзэхэд торгох ял 232 байхаас 143 буюу 62% нь биелж, эрх хасах ял 288 байхаас 57 буюу 20%-ийн биелэлттэй байна.

Эцэст нь тэмдэглэхэд, авлигын хэрэг маргаан шүүхээр шийдвэрлэгдэж буй байдал жил тутам өсөн нэмэгдэж байгаа бөгөөд тухайн хэргийн онцлог, нийгэмд ач холбогдолтой байдлыг харгалзан мэргэшсэн шүүгч ажиллуулах, тусгай шүүх байгуулах нь боломжит хувилбарын нэг юм. Түүнчлэн 2020 онд авлигын хэрэг нь Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн нийт хэргийн 0.9%, Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэсэн нийт хэргийн 3%, Хяналтын шатны шүүхээр шийдвэрлэсэн нийт хэргийн 2.5%-ийг тус тус эзэлж байгаа бөгөөд мэргэшсэн шүүгч эсхүл тусгай шүүх ажиллуулснаар Эрүүгийн хэргийн шүүхийн ачааллыг 2.1 орчим хувиар бууруулахаар байна.

ХОЁР. АВЛИГЫН ХЭРГИЙН ДАГНАСАН ШҮҮХТЭЙ ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ТУРШЛАГА

2020 оны 6 дугаар сарын 9-ний байдлаар дараах улсуудад авлигын хэргийг дагнан шийдвэрлэдэг шүүх байгууллагын институтууд оршиж байна. Үүнд:

№	Он	Улс орон
1	1979	Филиппин
2	1999	Пакистан
3	2002	Индонез
4		Непал
5	2003	Кени
6	2004	Бангладеш
7	2006	Бурунди
8	2008	Хорват
9		Уганда
10	2009	Словак
11	2010	Афганистан
12		Палестин
13	2011	Камерун
14		Малайз
15	2012	Болгар
16		Сенегал
17	2013	Ботсвана
18	2015	Мексик
19	2016	Танзани
20		Тайланд
21		Мадагаскар
22		Серби
23	2018	Шри Ланк
24		Украйн
25	2019	Албани
26		Сьерра Леон
27	2020	Зимбабве

2.1. Авлигын хэргийн дагнасан шүүх байгуулах хэрэгцээ, шаардлага

Дагнасан шүүх хэмээх ойлголт нь дэлхийн дахинд түгээмэл үзэгдэл юм. Дагнасан шүүх нь бусад ердийн шүүхтэй харьцуулахад үйл ажиллагааны үр нөлөө, бүтээмж өндөр, шуурхай процедуртай, хууль зүйн ээдрээ төвөгтэй салбарын маргаанд чанартай бөгөөд тогтвортой шүүхийн шийдвэрийг гаргах илүү боломжтой байдаг зэрэг олон давуу талтай. Авлигын хэргийн дагнасан шүүхийн хувьд эдгээр онцлог давуу тал мөн адил хамаарах хэдий ч тус төрлийн шүүхийг байгуулах хэрэгцээ, шаардлагыг дараах 3 хүчин зүйл бүрдүүлдэг гэж үзэж болох юм. Үүнд 1. Үр нөлөө, 2. Шударга байдал, 3. Мэргэшсэн байдал хамаарна.

2.1.1. Үр нөлөө

Авлигын хэргийн дагнасан шүүх байгуулах хамгийн түгээмэл шалтгаан, үндэслэл нь авлигын хэргийг хянан шийдвэрлэж буй шүүх системийн үр нөлөө, бүтээмжийг нэмэгдүүлэх явдал юм. Үр нөлөө, бүтээмжийг нэмэгдүүлэх дараах 3 арга хэрэгсэл бий.

1 дүгээрт авлигын хэрэг болон түүнтэй ижил төстэй хэргийг шийдвэрлэхэд нэг шүүгчид ногдох хэргийн тоог зохистой түвшинд байлгах. Энэ нь шүүгч хэргийг шуурхай шийдвэрлэх боломжийг бүрдүүлдэг.

2 дугаарт авлигын хэргийн дагнасан шүүхийн процесс ажиллагааг хялбаршуулах. Тухайлбал зарим улсад анхан шатны авлигын хэргийн дагнасан шүүхийн шийдвэрт гомдол гаргахад давж заалдах шатны шүүхээр дамжилгүй шууд дээд шүүхэд ханддаг жишиг бий (жишээ нь Бурунди, Камерун, Хорват, Непал, Пакистан, Словак гэх мэт). Мөн зарим улсад

ердийн болон дагнасан шүүхэд Үндсэн хуулийн шинжтэй асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх боломжгүй байдаг бөгөөд ердийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Үндсэн хуулийн асуудал хөндөгдөхөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, тухайн хэргийг Үндсэн хуулийн шүүхэд шилжүүлж, Үндсэн хуулийн шүүх нь тус хэргийг Үндсэн хуулийн талаас нь хянаж шийдвэрээ гаргасны дараа өмнө нь шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлж байсан шүүх рүү хэргийг буцаадаг практик байдаг. Энэ нь авлигын хэргийн шүүгдэгчдийн хувьд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хойшлуулж, удаашруулах нэг нөхцөл болдог тул тухайлбал Ботсвана улсад дээд шатны шүүхийн дэргэдэх авлигын хэргийн шүүхэд Үндсэн хуулийн асуудлыг шийдвэрлэх эрхийг олгосон бол, Уганда улсад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Үндсэн хуулийн шинжтэй маргаан үүссэн бол хэргийг шууд Үндсэн хуулийн шүүх рүү шилжүүлдэг байсан өмнөх практикийг өөрчилж, авлигын хэргийн дагнасан шүүх нь тухайн маргаан дагуулж буй асуудал нь Үндсэн хуулийн шинжтэй асуудал мөн үү үгүй юу гэдгийг урьдчилан шийдвэрлэх эрхтэй болсон байна.

3 дугаарт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг тогтоож өгөх. Тухайлбал зарим улсуудад 10 хоног, 1 жил, 3 сар, 6 сар, 30 хоног гэх зэргээр хэрэг хянан шийдвэрлэх хугацааг янз бүрээр тогтоосон нь тухайн шүүхийн бүтэц, чиг үүрэг, зохион байгуулалтаас хамаардаг.

2.1.2. Шударга байдал

Авлигын хэргийн дагнасан шүүх байгуулах хэрэгцээ шаардлагыг илтгэх 2 дахь хүчин зүйл нь авлига, улс төрчид болон бусад эрх мэдэл, нөлөө бүхий этгээдийн зүй бус нөлөөлөлд автахгүй, авлигын хэргийг тэгш, шударгаар шийдвэрлэх, хараат бус, бие даасан шүүхийн баталгааг бий болгох явдал юм.

Энэхүү баталгааг бий болгоход улс орнууд дараах хүчин чармайлтыг гаргаж байна. Тухайлбал Индонез улсын шүүх систем нь авлигад ихээр автсан тул нийтийн албан тушаалтан болон тэдгээрийн танилтай холбогдсон авлигын хэргийг шүүх шударгаар шийдвэрлэх баталгааг хангахад нэн хүндрэлтэй байдаг. Иймд тус улсын эрх баригчид авлигын хэргийг шийдвэрлэхэд ердийн шүүхэд ажилладаггүй “Ad hoc” judge буюу түр шүүгчийг шүүх бүрэлдэхүүнд оролцуулах зэрэг арга хэмжээг авсан байна. Мөн Словак улсад тусгай эрүүгийн хэргийн шүүхэд орон нутгийн элитүүдтэй холбоотой томоохон хэмжээний авлигын хэргийг шийдвэрлэх шүүхийн харьяаллыг олгосон. Учир нь тэдгээр орон нутгийн элитүүд нь тухайн орон нутгийн шүүхийн шийдвэр гаргах ажиллагаанд нөлөөлөх боломжтой байдаг тул тийм нөлөөллөөс ангид байлгахын тулд тус улсын нийслэлд орших үндэсний шүүх болох тусгай эрүүгийн хэргийн шүүхэд шүүхийн харьяаллыг олгосон байна.

2.1.3. Мэргэшсэн байдал

Авлигын хэргийн дагнасан шүүх байгуулах хэрэгцээ, шаардлагыг илтгэх 3 дахь хүчин зүйл нь тус шүүхийн үр нөлөөг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор урган гарах шүүгчийн мэргэшсэн байдал юм. Шүүгчийн мэргэшил яагаад чухал вэ гэвэл олонх авлигын хэргүүд нь бусад төрлийн хэргээс ялгаатай нь нарийн төвөгтэй санхүүгийн асуудалтай холбоотой байдаг. Иймд 1 дүгээрт авлигын хэргийн дагнасан шүүхийн шүүгч нарт санхүүгийн асуудал, нягтлан бодох бүртгэл, мөнгө угаах гэмт хэргийн эсрэг хууль зүйн зохицуулалтын талаар сургалт явуулах хэрэгтэй. 2 дугаарт зарим улс орнуудад авлигын хэргийн дагнасан шүүхийн шүүгч нарт онцгой мэргэшсэн байдлыг шаардаагүй байна. Тухайлбал Малайзад авлигын хэргийн дагнасан шүүхийн шүүгч нь тус шүүх болон бусад шүүхэд сэлгэж ажилладаг нь дагнаж мэргэшсэн шүүхэд ердийн шүүгч ажилласнаар тус шүүхийн мэргэшсэн байдлыг үгүйсгэх сул талтай хэмээх шүүмжлэлийг дагуулдаг.

2.2. Авлигын хэргийн дагнасан шүүхийг байгуулахад анхаарах асуудал

Тус шүүхийг байгуулахад хамгийн зөв загвар, сайн туршлага болох гэсэн ойлголт байхгүй бөгөөд тухайн улс өөрийн онцлогт тохирох хамгийн тохиромжтой загварыг бий

болгох нь маш олон хүчин зүйлээс хамаарах юм. Гэхдээ энэ төрлийн шүүхийг байгуулах гэж буй ямар ч улс орон дараах 5 хүчин зүйлийг анхаарах нь зүйтэй юм. Үүнд 1. Шүүхийн зохион байгуулалтын хэлбэр, 2. Шүүгчдийн тоо, 3. Шүүгчийг томилох болон огцруулах процесс, 4. Шүүхийн харьяалал, 5. Прокурорын байгууллагатай холбогдох харилцан хамаарал

2.2.1. Шүүхийн зохион байгуулалтын хэлбэр

Дараах үндсэн 4 хэлбэр байна. Үүнд:

1 дүгээр хэлбэр нь тусдаа, бие даасан танхим, салбар шүүх, дагнасан шүүх зэрэг хэлбэрээр бус ердийн шүүхийн шүүгчийг авлигын хэргийн шүүгчээр дагнуулж, мэргэшүүлэх хэлбэр юм. Энэ тохиолдолд тус шүүгчийн гаргасан шийдвэрийг давж заалдах шатны шүүх, хяналтын шатны шүүх хянах юм (Бангладеш, Кени гэх мэт улсууд хамаарна).

2 дугаар хэлбэр нь тусдаа, бие даасан авлигын хэргийн дагнасан шүүхийг байгуулах бөгөөд энэхүү шүүхийн шийдвэрийг шууд хяналтын шатны шүүх хянах юм. Иймд зарим тохиолдолд тус дагнасан шүүхийн шүүгч нь давж заалдах шатны шүүхийн шүүгчтэй эрх хэмжээний хувьд адил гэсэн үг юм (Бурунди, Камерун, Хорват, Непал, Пакистан, Сенегал, Словак гэх мэт улсууд хамаарна).

3 дугаар хэлбэр нь авлигын хэргийн дагнасан шүүх нь зарим авлигын хэргийг анхан шатны шүүхийн хэмжээнд авч шийдвэрлэдэг бол бусад авлигын хэргийг давж заалдах шатны шүүх нь шийдвэрлэдэг холимог загвар юм (Филиппин болон Уганда улсууд хамаарна). Тухайлбал Филиппинд авлигын хэргийн дагнасан шүүх нь өндөр дээд түвшний нийтийн албан тушаалтны холбогдсон авлигын хэргийг шийдвэрлэдэг бол доогуур түвшний албан тушаалтны үйлдсэн хэргийг орон нутгийн ердийн шүүхүүд хянан шийдвэрлэх бөгөөд тус шүүхийн гаргасан шийдвэрийг дагнасан шүүх нь давж заалдах шатны шүүхийн журмаар хянадаг.

Уганда улсын хувьд Филиппинтэй төстэй боловч энэ 2 улсын хувьд 2 чухал ялгаа бий. 1 дүгээрт Филиппиний дагнасан шүүхийн харьяалан шийдвэрлэх хэрэг нь хуулиар хязгаарлагдсан байдаг бол Угандагийн авлигын хэргийн шүүх нь ерөнхийдөө бүхий л авлигын хэргийг харьяалан шийдвэрлэх боловч илүү ноцтой, томоохон хэмжээний авлигын хэргийг анхан шатны журмаар шийдвэрлэдэг бөгөөд бусад авлигын хэргийг ердийн анхан шатны шүүхэд хянан шийдвэрлэдэг. Мөн Филиппиний авлигын хэргийн дагнасан шүүхийн шийдвэрийг тус улсын Дээд шүүх нь шууд хянадаг бол Угандагийн хувьд заавал давж заалдах шатны шүүхэд хянагдсаны дараа Дээд шүүхэд гомдол гаргах журамтай байна.

Мөн Ботсвана улсад бүх авлигын хэргийг эхлээд орон нутгийн анхан шатны шүүх хянан шийдвэрлэх бөгөөд тус шүүхийн шийдвэрийг давж заалдах тохиолдолд Ботсванагийн дээд шатны шүүхийн дэргэдэх авлигын хэргийн шүүхэд хандах зохицуулалттай байдаг. Иймд тус улсын авлигын шүүх нь зөвхөн давж заалдах журмаар хэргийг хянан шийдвэрлэх бөгөөд хэзээ ч анхан шатны журмаар хэргийг хянан шийдвэрлэдэггүй байна.

4 дэх хэлбэр нь Афганистан, Болгар, Малайз, Индонез зэрэг улсуудад түгээмэл байдаг анхан болон давж заалдах шатны аль аль шүүхэд авлигын хэргийн дагнасан шүүхийг байгуулах тогтолцоо юм.

Эдгээр үндсэн загваруудыг хүснэгтээр харуулбал доорх маягтай байна.

Загвар	Улс орон
Ганцаарчилсан шүүгч Авлигын хэргийг дагнан шийдвэрлэдэг, мэргэшсэн шүүгчийг бий болгосон. Уг шүүгчийн гаргасан шийдвэрийг ердийн журмаар давж заалдах боломжтой.	Бангладеш Кени
Анхан шатны шүүх Авлигын хэргийн дагнасан шүүхийг байгуулах бөгөөд уг шүүхийн гаргасан шийдвэрийг Дээд шүүх хянана.	Бурунди Камерун Хорват

	Непал Пакистан Сенегал Словак
Холимог шүүх Авлигын хэргийн дагнасан шүүх нь илүү ноцтой чухал авлигын хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх бөгөөд ердийн давж заалдах шатны шүүх нь ердийн шүүгчдийн хянан шийдвэрлэсэн авлигын хэргийг хянах зохицуулалттай байна.	Ботсвана Филиппин Уганда
Параллель шүүх Авлигын хэргийн дагнасан шүүх нь анхан болон давж заалдах шатны аль алинд нь зохион байгуулагдсан байна.	Афганистан Болгар Индонез Малайз

2.2.2. Шүүгчдийн тоо

Авлигын хэргийн дагнасан шүүхэд олон тооны шүүгчдийг томилох, нэг шүүгчид ногдох хэргийн тоог цөөн байлгах нь авлигын хэргийг шуурхай, үр нөлөөтэй шийдвэрлэхэд ач холбогдолтой. Ялангуяа энэ нь шүүхэд олон тооны авлигын хэргийг шийддэг, шүүхийн ачаалал ихтэй оронд хамааралтай байж болно. Гэвч шүүгчдийн тоог нэмэгдүүлэх нь дараах 3 зардлыг бий болгодог.

1 дүгээрт нэг шүүгчид ногдох хэргийн тоог багасгаж, сайжруулах нь авлигын хэргийн дагнасан шүүх байгуулах цор ганц шалтгаан биш бөгөөд илүү чадварлаг, туршлагатай шүүгчдийг олж томилох нь чухал бөгөөд энэ нь чадварлаг хүний нөөц багатай оронд бэрхшээлтэй юм. Мөн авлигын хэргийн дагнасан шүүхийн шүүгчдийн тоог нэмэгдүүлэх нь энэхүү ажлын байрны үнэ цэнэ, ач холбогдлыг бууруулах сул талтай.

2 дугаарт мөн эсрэгээрээ өндөр чадварлаг шүүгчдийг авлигын хэргийн дагнасан шүүхийн шүүгчээр олноор нь томилох нь бусад шатны шүүх чадварлаг хүний нөөцийн дутагдалд орох сөрөг нөлөөтэй.

3 дугаарт авлигын хэргийн дагнасан шүүхэд зөвхөн шударга, өндөр ёс зүйтэй шүүгчид ажиллах ёстой гэсэн шаардлага тавигддаг. Энэхүү шаардлагын улмаас зарим авлигын хэргийн дагнасан шүүхтэй улсад тусгай сонгон шалгаруулах процессыг хуульчилсан байна. Гэвч энэ төрлийн дагнасан шүүхэд ажиллах шүүгч нь дээрх хатуу, чанд шалгуур шаардлагыг хангах нь бэрхшээлтэй байдаг.

Иймд улс орнууд авлигын хэргийн дагнасан шүүхэд хэчнээн шүүгч ажиллуулах нь тохиромжтой эсэх шийдвэрийг гаргахдаа шүүгчдийн тоо болон шүүхийн нөөц бололцоонд сөрөг нөлөө үзүүлэхгүй хэмжээнд, нэг шүүгчид ногдох хэргийн тооны зөв харьцааг сайн тунгаах хэрэгтэй. Тухайлбал авлигын хэрэг их гардаг бөгөөд чадварлаг шүүгчдийн хүний нөөц сайтай оронд том хэмжээний авлигын шүүх байгуулах нь ач холбогдолтой бол дагнасан шүүх байгуулах хэмжээний авлигын хэрэг харьцангуй цөөн гардаг, мөн чадварлаг шүүгчдийн хүний нөөц багатай оронд илүү жижиг хэмжээний шүүх байгуулах нь зохистой байж болох юм.

2.2.3. Шүүгчийг томилох болон огцруулах процесс

Ихэнх улсад авлигын хэргийн дагнасан шүүхийн шүүгч нь бусад ердийн шүүхийн шүүгчтэй эрх зүйн байдлын хувьд ижил байх бөгөөд тус шүүхийн шүүгчдийг томилох, огцруулах, чөлөөлөх, хяналт тавих, ажиллах хугацаа болон нөхцөл нь бусад шүүгчтэй адил байдаг. Гэвч цөөн тооны улсад авлигын хэргийн дагнасан шүүхийн шүүгчид тусгай зохицуулалт үйлчлэх бөгөөд ялангуяа тухайн шүүгчдийг томилох процесс нь ердийн шүүгчдийнхээс өөр байх тохиолдол бий. Тухайлбал шүүгчдийг томилох процесс болон шүүгчид тавигдах мэргэшлийн шаардлагууд нь өөр байна. Энэ нь тухайн шүүгчийг авлигын хэргийн дагнасан шүүхийн шүүгчээр томилогдохын өмнө хангалттай зэрэг дэв, туршлагатай

байхыг шаарддаг гэсэн үг юм. Жишээ нь Словакад авлигын хэргийн дагнасан шүүхийн шүүгчийг томилохоос ямар нэг эргэлзээ сэжиг төрүүлэхүйц мэдээлэл, зохисгүй нөлөөлөл үзүүлж болох эсэх зэргээр түүний өнгөрсөн намтрыг судлах процесс ажиллагаа явагддаг.

2.2.4. Шүүхийн харьяалал

Авлигын хэргийн шүүхийн харьяалал нь их өргөн хүрээтэй байдаг. Гэхдээ улс орнууд дараах 3 гол шинжээр хоорондоо ялгагддаг. 1. Хэргийн төрөл, зүйл, 2. Хэргийн хүнд, хөнгөн эсэх шинж, 3. Шүүгдэгчийн шинж үүнд хамаарна.

1. Хэргийн төрөл, зүйл: Ихэнх авлигын хэргийн дагнасан шүүх нь бүхий л төрлийн авлигын хэрэг болон авлигатай холбоотой гэмт хэргийг харьяалан шийдвэрлэдэг. Мөн авлигын хэргийн дагнасан шүүх нь зөвхөн авлига болон эдийн засгийн гэмт хэрэгтэй холбоотой хэргийг хянан шийдвэрлэхээс гадна бусад төрлийн хүнд ноцтой эрүүгийн гэмт хэргийг харьяалан шийдвэрлэх зэрэг өргөн хүрээний шүүхийн харьяалалтай байдаг. Тухайлбал Хорватын шүүх өндөр түвшний авлигын хэргээс гадна бусад төрлийн зохион байгуулалттай гэмт хэргийг хянан шийдвэрлэдэг. Болгарын тусгай эрүүгийн хэргийн шүүх нь мөн адил зохион байгуулалттай гэмт хэрэг болон авлигын хэргийг хянан шийдвэрлэдэг. Словакийн тусгай эрүүгийн хэргийн шүүх нь зохион байгуулалттай гэмт хэрэг, санаатай хүн амины хэрэг, авлига, мөнгө угаах гэмт хэргийг хянан шийдвэрлэдэг. Непалын тусгай шүүх нь авлига болон мөнгө угаах гэмт хэргийг хянан шийдвэрлэхээс гадна эх орноосоо урвах гэмт хэргийг харьяалан шийдвэрлэдэг. Мөн үүний яг эсрэгээр зарим орны авлигын хэргийн дагнасан шүүхийн хэргийн харьяалал нь маш явцуу, хумигдмал хүрээнд байдаг. Тухайлбал Сенегалын хууль бусаар хөрөнгөжих явдлыг таслан зогсоох шүүх нь уг нэрийнхээ дагуу зөвхөн хууль бусаар хөрөнгөжих гэмт хэргийг хянан шийдвэрлэдэг.

2. Хэргийн хүнд, хөнгөн эсэх шинж: Зарим улсын шүүх нь хэргийн шинж чанараас илүүтэй хохирлын хэмжээгээр хэргийн харьяаллыг тогтоодог. Тухайлбал зарим улсын шүүх зөвхөн их үнийн дүнтэй хэргийг харьяалан шийдвэрлэдэг. Жишээ нь Камерун улсын тусгай эрүүгийн хэргийн шүүх нь зөвхөн их үнийн дүнтэй хөрөнгө завших гэмт хэргийг хянан шийдвэрлэдэг бөгөөд бусад хөрөнгө завших гэмт хэргийг ердийн шүүхүүд хянан шийдвэрлэдэг. Мөн Филиппин улс нь тодорхой босго хязгаарыг давсан үнийн дүнтэй хэргийг дагнасан шүүх харьяалан шийдвэрлэдэг байхаар хуульдаа нэмэлт өөрчлөлт оруулсан юм.

3. Хариуцагчийн шинж: Зарим улсад хэргийн төрөл, зүйл, шинжээр нь шүүхийн харьяаллыг тогтоохоос гадна шүүгдэгчээр нь хязгаарласан байна. Тухайлбал Филиппиний шүүх зөвхөн өндөр дээд түвшний нийтийн албан тушаалтны үйлдсэн авлигын хэргийг хянан хэлэлцдэг. Харин Бурунди улсын шүүх яг үүний эсрэг бөгөөд харин тус улсын өндөр дээд түвшний нийтийн албан тушаалтан тухайлбал сайд, дэд сайд, орлогч, сенатын гишүүн, генерал, орон нутгийн захиргааны удирдагч, ахлах шүүгч зэрэг албан тушаалтны холбогдсон хэргийг зөвхөн тус улсын Дээд шүүх нь хянан шийдвэрлэдэг.

2.2.5. Прокурорын байгууллагатай холбогдох харилцан хамаарал

Авлигын хэргийн дагнасан шүүх нь авлигатай тэмцэх газар, түүнтэй төстэй прокурорын байгууллагатай шууд холбогдох бөгөөд уг шүүхийн хэргийн харьяалал нь авлигатай тэмцэх газрын үүсгэсэн хэргээр хязгаарлагдах тохиолдол бий. Зарим тохиолдолд авлигатай тэмцэх газар нь авлигын хэргийн дагнасан шүүхэд хэрэг үүсгэх эрхтэй байдаг. Зарим авлигын хэргийн дагнасан шүүх, түүн дотроос Францын хуулийн нөлөө их орсон орнуудад авлигын хэргийн тусгайлсан прокурор, мөрдөгч нар нь авлигын хэргийн дагнасан шүүхэд харьяалагдах бөгөөд тэдгээр прокурорууд шүүхэд хэрэг үүсгэж, мөн хэргийг бусад харьяалах байгууллага руу шилжүүлэх эрхтэй байдаг. Ийм улсын жишээнд Бурунди, Камерун, Сенегал зэрэг улсууд багтдаг.

Харин үүний эсрэгээр зарим авлигын хэргийн дагнасан шүүх нь ердийн прокурорын байгууллагаас үүсгэсэн хэргийг хянан хэлэлцдэг бөгөөд учир нь тухайн улс нь авлигатай

тэмцэх газар байхгүй эсхүл авлигатай тэмцэх газар нь шүүхэд авлигын хэрэг үүсгэх эрх мэдэлгүй байдагтай холбоотой. Ийм улсын жишээнд Малайз, Кени багтах бөгөөд эдгээр улсуудад ердийн прокурорын байгууллага (авлигатай тэмцэх газар биш) авлигын хэргийн дагнасан шүүхэд хэрэг үүсгэх эрхтэй байдаг.

Мөн зарим улсад авлигын хэргийн дагнасан шүүх нь авлигатай тэмцэх газар эсхүл ердийн прокурорын байгууллагын үүсгэсэн хэргийг хянан хэлэлцдэггүй. Тухайлбал Уганда улсын дээд шатны шүүхийн дэргэдэх авлигын хэргийн шүүх нь улсын ерөнхий прокурор, улсын ерөнхий мөрдөн байцаагч мөн улсын орлогыг бүрдүүлэх газраас үүсгэсэн хэргийг хянан шийдвэрлэдэг.

Энэ мэтчилэн зохицуулалтын олон төрөл хэлбэр байх боловч хамгийн гол нь авлигын эсрэг шүүх системийг бүрдүүлэхэд авлигатай тэмцэх газар, авлигын хэргийн дагнасан шүүх, хууль сахиулах байгууллагууд бүгд үр дүнтэй зэрэгцэн ажиллах шаардлагатай юм.


3. Хэсгийн дүгнэлт

Дээрх судалгаанаас үзэхэд авлигын хэргийн дагнасан шүүхийг бий болгох эсэхийг шийдэхдээ дараах хэдэн хүчин зүйлийг зайлшгүй харгалзан үзэх шаардлагатай байна. Үүнд:

- Шүүхийн шаталсан тогтолцоо дахь авлигын хэргийн дагнасан шүүхийн эзлэх байр суурь. Энэ нь авлигын хэргийн дагнасан шүүх нь анхан шатны шүүх байх уу эсхүл давж заалдах шатны шүүх байх уу, эсхүл аль аль шүүхийн шатанд байх шаардлагатай юу. Мөн аль шатны шүүх авлигын хэргийн дагнасан шүүхийн шийдвэрийг хянах вэ гэдгийг тооцох.
- Ажиллах шүүгчдийн тоо. Авлигын хэргийн дагнасан шүүхэд хэчнээн шүүгч ажиллах шаардлагатай вэ, эсхүл хэчнээн шүүгчийг авлигын хэргийн мэргэшсэн шүүгч болгох вэ гэдгийг анхаарах.
- Шүүхийн харьяалан шийдвэрлэх хэрэг. Тус шүүх нь ямар төрлийн авлигын хэргийг хянан шийдвэрлэх вэ гэдгийг тодорхойлох. Шүүхийн харьяалал нь өргөн байх уу эсхүл явцуу, нарийн хүрээнд байх уу гэдгийг шийдэх. Хэрвээ явцуу, нарийн хүрээнд байна гэвэл түүнийгээ тодорхой болгох.
- Авлигын хэргийн дагнасан шүүх болон прокурорын байгууллага хоорондын уялдаа холбоо. Энэ төрлийн шүүх нь хэр үр нөлөөтэй ажиллах нь тухайн шүүхэд хэрэг үүсгэх эрхтэй бусад байгууллагуудын үр нөлөөтэй ажиллагааны үр дүнгээс шууд хамаарна.
- Авлигын хэргийн дагнасан шүүхийн шүүгчийг сонгон шалгаруулах, томилох, огцруулах болон тус шүүгчийн ажиллах нөхцөлийг хангахтай холбоотой тусгай зохицуулалт шаардлагатай эсэх. Мөн тус шүүхийн шүүгчид бусад ердийн шүүгчтэй адил эрх зүйн байдал, нөхцөлд ажиллах уу гэдгийг тодорхой болгох.
- Авлигын хэргийн дагнасан шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тусгай зохицуулалт шаардлагатай эсэхийг шийдвэрлэх зэрэг хамаарна.

Дээрх хэсэгт авлигын хэргийн дагнасан шүүхийг байгуулах хэрэгцээ, шаардлага, уг шүүхийн онцлог шинж, энэ төрлийн шүүхийг шинээр бий болгоход анхаарах зарим асуудлыг авч үзсэн бол дараагийн хэсэгт тухайлсан улсын жишээн дээр эдгээр асуудал хэрхэн тусгалаа олсныг нарийвчлан авч үзье.

2.3. Словак улсын авлигын хэргийн дагнасан шүүх



2003 онд Словакийн парламент авлига болон зохион байгуулалттай гэмт хэргийн дагнасан шүүхийг байгуулж, уг шүүх нь 2005 оноос чиг үүргээ хэрэгжүүлж эхэлсэн. Мөн уг шүүхэд хэрэг үүсгэх эрхтэй тусгай прокурорын байгууллагыг байгуулсан. Гэтэл 2009 онд Словакийн Үндсэн хуулийн шүүх уг дагнасан шүүхийг Үндсэн хууль зөрчсөн хэмээн үзсэн тул тус улсын парламент уг шүүхийг дахин өөрчлөн байгуулах, Үндсэн хуульд нийцүүлсэн цөөн хэдэн өөрчлөлт хийх хуулийг баталсан. Ингэснээр уг шүүх нь Тусгай эрүүгийн хэргийн шүүх гэсэн нэртэйгээр чиг үүргээ үргэлжлүүлэн хэрэгжүүлэх болсон юм.

Словакийн шүүхийн тогтолцоонд ихэнх ердийн эрүүгийн гэмт хэргийг 54 дүүргийн шүүх анхан шатны журмаар хянан шийдвэрлэх бөгөөд тэдгээр шүүхийн шийдвэрийг 8 орон нутгийн давж заалдах шатны шүүх хянадаг бол давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг тус улсын Дээд шүүх хянадаг. Тусгай эрүүгийн хэргийн шүүхийн шүүгч нь орон нутгийн давж заалдах шатны шүүгчтэй статусын хувьд адил боловч уг шүүх нь хэргийг анхан шатны шүүхийн журмаар шийдвэрлэх чиг үүрэгтэй бөгөөд гарсан шүүхийн шийдвэрийг шууд тус улсын Дээд шүүх хянадаг. Уг шүүх нь авлига, мөнгө угаах гэмт хэрэг, зохион байгуулалттай гэмт хэрэг, санаатай хүн амины гэмт хэрэг гэх мэт бусад төрлийн онц ноцтой эрүүгийн гэмт хэргийг харьяалан шийдвэрлэдэг. Тус шүүх нь ерөнхий шүүгч болон бусад шүүгчдээс бүрдсэн нийт 13 шүүгчтэй. Харьцангуй хөнгөн гэмт хэргийг шүүгч дангаар шийдвэрлэдэг бол бусад төрлийн хүнд гэмт хэргийг даргалагч болон бусад шүүгчдээс бүрдсэн 3 шүүгчийн бүрэлдэхүүнээр хянаж, олонхын саналаар хэргийг хянан шийдвэрлэдэг.

Тус шүүхийн шүүгчийг томилох, огцруулах процесс нь бусад ердийн шүүхийн шүүгчтэй адил байдаг. Уг шүүхийн шүүгчээр томилогдохын тулд шүүхийн сонгон шалгаруулах процесст тэнцэх, тус улсын Шүүхийн ерөнхий зөвлөлөөс сонгогдсон Сонгон шалгаруулах комисст (Комисс нь 9 шүүгч болон засгийн газрын бусад салбараас сонгогдсон 9 гишүүдээс бүрдэнэ) өөрийн нэрийг өгсөн байх шаардлагатай. Сонгон шалгаруулах комисс нь Шүүхийн ерөнхий зөвлөлөөс томилогдох эсхүл үл томилогдох нэр дэвшигчийг сонгодог. Тус шүүхийн шүүгчээр томилогдох нэр дэвшигч нь Үндэсний аюулгүй байдлын байгууллагын хяналт шалгалтаар шалгагдсан байх шаардлагатай бөгөөд тус байгууллага нь хяналт шалгалтыг хүчингүй болгох эрхтэй.

Словакийн шүүхийн туршлагыг судлахад дараах 4 асуудалд анхаарал хандуулах нь зүйтэй. 1. Шүүгчийг сонгон шалгаруулах тусгай процесс, 2. Тусгай ажиллах нөхцөл, 3. Прокурорын байгууллагаас хамаарах хамаарал, 4. Шүүхийн харьяалал зэрэг хамаарна.

1. Шүүгчийг сонгон шалгаруулах тусгай процесс

Тус улсад дагнасан шүүх төдийгүй бусад бүх шүүхийн шүүгчийг сонгон шалгаруулж, томилоход тухайн хүний өмнөх намтрыг судалж, шүүгчийн шударга байдал, ёс зүйд харшлах түүх бий эсэхийг тогтоох нь шүүн таслах ажиллагааны шударга байдлыг хангана

гэж үздэг. Гэвч энэ нь нөгөө талаас шүүхийн хараат бус, бие даасан байдалд сөрөг нөлөөтэй гэж үзэх хандлага байдаг.

2. Тусгай ажиллах нөхцөл

Дагнасан шүүхийн шүүгчдийн ажиллах нөхцөл нь бусад шүүхийн шүүгчтэй бараг адил боловч цалингийн хувьд ялгаатай байдаг. Учир нь тухайлбал зохион байгуулалттай гэмт хэргийг хянан шийдвэрлэх үед шүүгчийн аюулгүй байдал эрсдэлд ордог тул уг дагнасан шүүхэд ажиллах шүүгчийг олж томилох нь бэрхшээлтэй байв. Иймд засгийн газраас уг шүүхэд ажиллах шүүгчийн цалинг бусад ердийн шүүхийн шүүгчийнхээс өндөр болгох шийдвэрийг гаргасан боловч энэ нь бусад шүүгчийн дургүйцлийг хүргэсэн тул шүүгчдийн зүгээс Үндсэн хуулийн шүүхэд уг асуудлаар хандсанаар энэ нь Үндсэн хуулийн зөрчилд тооцогдож, дагнасан шүүхийн шүүгчдийн цалингийн зөрүүг шүүмжлэл дагуулахгүй хэмжээнд арай багасгах шийдвэр гаргасан байна.

3. Прокурорын байгууллагаас хамаарах хамаарал

Тус дагнасан шүүх нь прокурорын байгууллагын үүсгэсэн авлигын хэргийг хянан шийдвэрлэдэг боловч ихэнх тохиолдолд тэдгээр нь доод түвшний нийтийн албан тушаалтны холбогдсон, бага үнийн дүнтэй хэргийг хянан шийдвэрлэдэг. Энэ нь шүүх дээр илүү чухал, томоохон авлигын хэргүүд шийдэгдэхгүй байна гэх шүүмжлэлийг дагуулдаг. Учир нь прокурорын байгууллага нь хангалттай нотлох баримт байсан ч гэсэн нөлөө бүхий хүмүүсийн авлигын хэрэгт хариуцлага хүлээлгэх сонирхолгүй байдагтай холбоотой аж.


4. Шүүхийн харьяалал

Тус дагнасан шүүхийн харьяалал нь хэргийн төрөл зүйлээр тодорхойлогдох бөгөөд хэргийн хүнд, хөнгөн шинж хамаардаггүй. Мөн тус шүүх нь мөнгөн дүн, шүүгдэгчийн статус хамаарахгүйгээр бүхий л төрлийн авлигын хэргийг хянан шийдвэрлэдэг өргөн хүрээний хэргийн харьяалалтай шүүх юм.

5. Словакийн шүүхийн туршлагаас ойлгох зүйл

- Шүүгчийг сонгон шалгаруулах тусгай процесс ажиллагааг хуульчлах (шүүгчид нэр дэвшигчдийн өнгөрсөн намтар түүх, хувийн мэдээллийг судлах) бол шүүн таслах ажиллагааны шударга байдал болон шүүхийн бие даасан, хараат бус байдлыг хангах хоёрын хоорондох тэнцвэрт харьцааг хангахыг эрмэлзэх
- Дагнасан шүүхэд ажиллах шүүгчдийн цалин хөлс, ажиллах нөхцөлийг бусад шүүхийн шүүгчдээс арай өндөр түвшинд тогтооход болгоомжтой хандах
- Дагнасан шүүх нь орон нутгийн улс төрчдийн нөлөөллөөс ангижирсан боловч үндэсний хэмжээний томоохон авлигын хэрэг шүүх дээр ирэхгүй байгааг анхаарах
- Дагнасан шүүхийн үр нөлөө нь хууль сахиулах болон прокурорын байгууллагын үйл ажиллагаанаас ихээхэн хамаардгийг анхаарах. Хэрвээ хууль сахиулах байгууллагууд нотлох баримтыг хангалттай хэмжээнд цуглуулж, бүрдүүлэхгүй, прокурорын байгууллага шүүхэд авлигын хэрэг үүсгэхгүй бол хэчнээн сайн зохион байгуулагдсан шүүх байсан ч үр нөлөөтэй ажиллаж чадахгүй.
- Дагнасан шүүхийн харьяаллыг хуульчлахад анхаарал хандуулах. Ялангуяа чухал, томоохонд тооцогдох авлигын хэргээр шүүхийн харьяаллыг хязгаарлах нь илүү олон хэрэг шийдвэрлэх боломжтой өргөн хүрээнд шүүхийн харьяаллыг тогтоохоос ямар давуу тал, ач холбогдолтойг үнэлэх шаардлагатай.

2.4. Филиппин улсын авлигын хэргийн дагнасан шүүх



Филиппин улсын авлигын хэргийн дагнасан шүүх нь энэ төрлийн шүүхийн хувьд дэлхий дээрх хамгийн анх байгуулагдсан шүүх юм. Уг шүүх нь 1979 оноос чиг үүргээ хэрэгжүүлсэн эхэлсэн байна. Филиппинд ердийн эрүүгийн хэргийг орон нутгийн болон нийслэлийн шүүх анхан шатны журмаар хянан шийдвэрлэдэг. Эдгээр анхан шатны шүүхийн шийдвэрийг давж заалдах шатны шүүх, хяналтын шатны шүүх хянадаг. Авлигын хэргийн дагнасан шүүх нь шүүхийн шатлалын хувьд давж заалдах шатны шүүхтэй адил боловч анхан шатны шүүхийн чиг үүргийг гүйцэтгэдэг. Тус шүүх нь шүүгдэгчийн хувьд төрийн өндөр дээд албан тушаалтан холбогдсон байх, мөн их хэмжээний үнийн дүнтэй хохирол учирсан байх гэсэн 2 шаардлагыг хангасан авлигын хэргийг харьяалан шийдвэрлэдэг. Хэрвээ энэхүү шаардлагыг хангаагүй авлигын хэрэг бол ердийн орон нутгийн шүүх тухайн хэргийг харьяалан шийдвэрлэх бөгөөд тус шүүхийн шийдвэрийг авлигын хэргийн дагнасан шүүхэд давж заалдах боломжтой. Мөн авлигын хэргийн дагнасан шүүхийн шийдвэрийн талаар тус улсын Дээд шүүхэд гомдол гаргах боломжтой юм. Авлигын хэргийн дагнасан шүүхэд Омбудсмены газар хэрэг үүсгэх эрхтэй.

Авлигын хэргийн дагнасан шүүх нь 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хэргийг хянан шийдвэрлэдэг. Ахмад, туршлагатай шүүгч нь шүүх бүрэлдэхүүнийг даргалж, олонхын саналаар хэргийг шийддэг. Авлигын хэргийн дагнасан шүүхийн шүүгчийг давж заалдах шатны шүүхийн шүүгчийг томилох процедуртай адил процедураар сонгож, томилдог. Уг шүүхэд сул орон тоо зарлагдахад хууль тогтоох, шүүх эрх мэдэл, хууль зүйн мэргэжилтэй бусад этгээд, гүйцэтгэх засаглалын төлөөлөл, хууль зүйн сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын төлөөлөл, хувийн секторын төлөөллөөс бүрдсэн Шүүх болон хуульчдын

зөвлөл шүүгчид нэр дэвшигчдийн материалыг хүлээн авч, тэдгээрээс дор хаяж 3 нэр дэвшигчийн жагсаалтыг гаргах бөгөөд ерөнхийлөгч уг жагсаалтаас шүүгчийн сул орон тоонд тохирох нэр дэвшигчийг сонгож, томилдог. Авлигын хэргийн дагнасан шүүхийн шүүгч нь өөрөө сайн дураар ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргаагүй, шүүгчээр ажиллах боломжгүй болсон, эсхүл алдаа зөрчил гаргасны улмаас Дээд шүүхээс огцруулаагүй бол 70 нас хүрч, шүүгчийн ажлаасаа чөлөөлөгдтөл шүүгчээр ажиллах боломжтой.

Филиппиний шүүх тогтолцоо нь хэргийг үр нөлөөтэй, шуурхай шийдвэрлэх тал дээр асуудалтай бөгөөд ялангуяа ээдрээ төвөгтэй хэргийг эцэслэн шийдэхэд хэдэн арван жилийг зарцуулдаг. Авлигын хэргийн дагнасан шүүхийн тухайд хэрэг үүсгэхээс эхлээд хэргийг эцэслэн шийдэх хүртэлх хугацаа нь дунджаар 7 жил, зарим цөөн тооны хэрэгт үүнээс их хугацаа зарцуулдаг. Шүүхийн хэргийн ачаалал маш өндөр бөгөөд жил бүр 3000 хэрэг хүлээн авдаг. Энэ асуудлыг шийдэхийн тулд 2015 онд тус шүүхийн шүүгчдийн ноог нэмэгдүүлж, хэргийн харьяаллыг хохирлын мөнгөн дүнгээр хязгаарласан босго тавих зэргээр хууль зүйн зохицуулалт хийсэн байна.

Филиппиний шүүхийн туршлагыг судлахад дараах 4 асуудалд анхаарал хандуулах нь зүйтэй. 1. Кэйс менежмент болон шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, 2. Прокурорын байгууллагатай холбогдох харилцан хамаарал, 3. Шүүхийн нөөц бололцоо, 4. Шүүхийн харьяалал зэрэг хамаарна.

1. Кэйс менежмент болон шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

Ихэнх судлаачид авлигын хэргийн дагнасан шүүхэд үргэлжилсэн, тасралтгүй шүүн таслах ажиллагаа шаардлагатай гэж үзсэн. Өөрөөр хэлбэл маш их хугацаа авдаг жижиг шүүх хурлуудыг зарлахаа болиод шүүн таслах ажиллагаа эхнээсээ дуустал бүрэн явагддаг байх гэсэн саналыг дэвшүүлсэн. Мөн шүүн таслах ажиллагааг хойшлуулж, удаашруулдаг зохицуулалтуудыг хязгаарлах хэрэгтэй гэж үзсэн.

2. Прокурорын байгууллагатай холбогдох харилцан хамаарал

Авлигын хэргийн дагнасан шүүхийн шүүн таслах ажиллагааны удаашрал нь Омбудсмены газрын үйл ажиллагаанаас хамаардаг гэж үздэг. Тодруулбал Омбудсмены газар нь шүүх хуралд бэлтгэдэггүйн улмаас шүүх хурлыг зайлшгүй хойшлуулах хүсэлт их тавьдаг. Гэвч нөгөө талаас авлигын хэргийн дагнасан шүүх нь прокурорын байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад нөлөөлөх боломжтой гэсэн байр суурь байх бөгөөд тухайлбал удаа дараа шүүх хурлыг хойшлуулах хүсэлтийг хүлээн авахгүй байх үндэслэлийг тодорхой болгосноор Омбудсмены газар шуурхай бөгөөд үр нөлөөтэй ажиллахад түлхэц болно гэж үздэг байна.

3. Шүүхийн нөөц бололцоо

Авлигын хэргийн дагнасан шүүхийн процедур, кэйс менежмент, шүүхийн харьяаллыг боловсронгуй болгохоос гадна нэг шүүгчид ногдох хэргийн тоог багасгаснаар тус шүүхийн ачааллыг бууруулна гэж үздэг. Иймд 2015 онд тус шүүхийн шүүгчдийн тоог 15-аас 21 болгосон боловч энэ нь хангалттай үр дүн гаргахад харьцангуй бага тоо юм гэх шүүмжлэл байхад шүүхийн нөөц бололцоог авлигын хэргийн дагнасан шүүхэд илүү хуваарилах нь ердийн шүүхээс шүүгчид гарах, дагнасан шүүхийн шүүгчийн чанарыг бууруулах зэрэг сөрөг үр дагавартай гэсэн хандлага ч байдаг.

4. Шүүхийн харьяалал

Авлигын хэргийн дагнасан шүүх нь өндөр түвшний нийтийн албан тушаалтан, үнийн дүн өндөртэй авлигын хэргийг харьяалан шийдвэрлэдэг байхаар 2015 онд хуульд өөрчлөлт орсон. Ингэснээр хуулиар тогтоосон авлигын хэргийн дагнасан шүүхийн харьяалалд хамаарахгүй ч нэлээд ноцтой авлигын хэргүүд ердийн орон нутгийн шүүхийн харьяалалд хамаарах бөгөөд эдгээр шүүх хэргийг шударга бөгөөд хараат бусаар шийдвэрлэж чадах эсэх нь зарим талаар эргэлзээтэй гэсэн байр суурь ч бий.

5. Филиппиний шүүхийн туршлагаас ойлгох зүйл

- Авлигын хэргийн дагнасан шүүх байгуулахад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон кэйс менежментийг хуулиар тохиромжтой зохицуулахгүй бол шүүхийн ачааллыг нэмэгдүүлж, шүүн таслах ажиллагааны удаашралыг бий болгодог гэдгийг анхаарах
- Прокурор болон шүүх тусдаа байгууллага боловч эдгээрийг нэг систем гэж авч үзэх, чиг үүргээ хамтдаа үр нөлөөтэй гүйцэтгэдэг байхад анхаарах
- Шүүгчдийн тоо болон шүүхэд зарцуулж буй шүүхийн нөөцөд анхаарах
- Шүүхийн харьяаллыг зохистойгоор тогтооход анхаарах. Тухайлбал нийтийн албан тушаалтны зэрэглэл, хэргийн хүнд, хөнгөн зэрэг шинж зэргээр ялгавартай тогтоох

2.5. Индонез улсын авлигын хэргийн дагнасан шүүх



Тус шүүх нь 2002 оны хуулиар зохион байгуулагдаж, 2004 оноос чиг үүргээ хэрэгжүүлж эхэлсэн. 2010 оныг хүртэл тус шүүхийн анхан шат нь нийслэл Жакарта хотын дүүргийн шүүхэд харьяалагдаж, давж заалдах шатны шүүх нь Жакарта хотын дээд шатны шүүхэд харьяалагддаг байсан бөгөөд тус шүүхийн шийдвэрийг Улсын Дээд шүүх хянадаг байв. Эдгээр шатны шатны шүүхэд 2 байнгын шүүгч, 3 түр шүүгчээс бүрдсэн 5 шүүгч ажилладаг байв. Түр шүүгч нь шүүх системийн гаднаас, Дээд шүүхийн олон шатлалт шалгуураар сонгогдож, 5 жилийн хугацаатай томилогддог байв. Мөн 2002 оны хуулиар Индонезийн авлигатай тэмцэх газрыг байгуулсан бөгөөд авлигын хэргийн дагнасан шүүх нь зөвхөн уг байгууллагын үүсгэсэн хэргийг хянан хэлэлцдэг. Харин прокурорын байгууллагын үүсгэсэн авлигын хэргийг бусад ердийн шүүхүүд хянан шийдвэрлэдэг байв.

2006 онд тус улсын Үндсэн хуулийн шүүхээс авлигын хэргийг 2 өөр байгууллага хянан шалгахыг Үндсэн хууль зөрчсөн хэмээн үзсэн. Ингэснээр 2009 онд авлигын хэргийн дагнасан шүүх нь авлигатай тэмцэх газар, эсхүл прокурорын байгууллага хянан шалгасныг үл харгалзан бүхий л авлигын хэргийг харьяалан шийдвэрлэдэг болсон юм. 2 жилийн дотор 34 мужийн нийслэлд орон нутгийн авлигын хэргийн шүүх байгуулагдаж, мөн дараа нь бүх дүүрэг, хотуудад байгуулагдсан байна.

Авлигын хэргийг дүүргийн шүүх анхан шатны журмаар шийдвэрлэх бөгөөд уг шүүхийн шийдвэрийг дээд шатны шүүхэд давж заалдах, хяналтын шатны шүүхэд хянуулах боломжтой юм. Жакарта хотын дүүргийн шүүхийн дэргэдэх авлигын хэргийн дагнасан шүүх нь гадаад улсад Индонезийн иргэний үйлдсэн авлигын хэргийг хянан шийдвэрлэх онцгой эрхтэй байна.

Шинэ хуулиар авлигын хэргийн дагнасан шүүхэд 2 байнгын шүүгч, 3 түр шүүгч ажиллах зохицуулалтыг өөрчилж, оронд нь ердийн шүүхийн удирдлагууд нь авлигын хэргийн шүүхийн шүүх бүрэлдэхүүнийг сонгох эрхийг олгосон юм. Шүүх бүрэлдэхүүн нь сондгой тоотой байх ёстой бөгөөд бүрэлдэхүүнд байнгын болон түр шүүгчийг заавал оролцуулах ёстой хэвээр байна.

1. Үр нөлөө

1 дүгээрт авлигын хэргийн дагнасан шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх хугацааг хуулиар тогтоосон. Тухайлбал анхан шатны шүүх хэргийг 120, давж заалдах шатны шүүх 60, хяналтын шатны шүүх 120 хоногт хэргийг хянан шийдвэрлэхээр зохицуулсан. Гэвч 2014 оны байдлаар тусгай эрүүгийн хэргийн 80 орчим хувь нь анхан шатны шүүхэд 12 сараас доошгүй хугацаанд, давж заалдах шатны шүүхэд 1 жилээс илүү хугацаанд шийдвэрлэгддэг.

2 дугаарт авлигын хэргийн дагнасан шүүх төдийгүй бусад нийт шүүхэд хамаарах томоохон тулгамдсан асуудал нь шүүх хурал хойшлогдож, шүүн таслах ажиллагаа удаашрах явдал юм. Шүүхийн практикт хэргийн оролцогчид бүрэн цугларсан хэргийг хамгийн түрүүнд хянан хэлэлцдэг боловч энэ нь бодит байдал дээр ирээгүй оролцогчдыг удаан хугацаагаар хүлээх зэргээр эмх замбараагүй байдлыг үүсгэж, шүүн таслах ажиллагааны үр нөлөөг багасгадаг.

3 дугаарт авлигын хэргийн дагнасан шүүхийн шүүх бүрэлдэхүүнд багтах байнгын шүүгч нь бусад ердийн шүүхэд авлигатай холбоогүй хэргийн шүүн таслах ажиллагаанд оролцдог нь уг шүүгчийн үр нөлөөтэй ажиллахад төвөг учруулдаг. Хуулиар авлигын хэргийг шийдвэрлэж байгаа шүүгчийг бусад хэргийн шүүн таслах ажиллагаанаас чөлөөлөх боловч энэ нь практикт хэрэгждэггүй. Энэ байдлыг үр нөлөөтэй хэрэг хуваарилалт талаас нь харвал шүүгч цөөн тооны авлигын хэргийг шийдвэрлэж байх үедээ бусад хэргийг давхар шийдэх нь үр дүнтэй байж болно. Гэвч нөгөө талаас олон тооны авлигын хэргийг шуурхай шийдэх талаас нь харвал энэ байдлыг дахин харж үзэх шаардлагатай юм.

2. Шударга, хараат бус, бие даасан байдал

Авлигын хэргийн дагнасан шүүх байгуулах гол шалтгаан нь одоогийн шүүх тогтолцоо нь авлигын хэргийг шударга, үр нөлөөтэй шийдвэрлэх итгэл бага байсантай холбоотой юм. Хууль тогтоогчид авлигын хэргийн шүүхийн шүүх бүрэлдэхүүний ихэнхийг түр шүүгчээр бүрдүүлж, олонхын саналаар хэргийг шийдэх нь шүүхийг зүй бус нөлөөлөлд автахас сэргийлнэ гэж үзсэн. Гэсэн хэдий ч бодит байдал дээр нэлээд хэдэн түр шүүгчид (мөн байнгын шүүгч ч гэсэн) авлига авсан нь тэдгээр шүүгчдийн системийн гаднаас орж ирсэн цэвэр, шударга шүүгч гэсэн имижид сөргөөр нөлөөлсөн. Үүний учир шалтгааныг Дээд шүүх, үндэсний хэвлэл мэдээллийн шууд хяналт хангалтгүй байдагтай холбон тайлбарладаг. Мөн түр шүүгчийн цалин хөлс нь тусгай баталгааг эдэлдэг байнгын шүүгчээс доогуур байдаг.

3. Мэргэшсэн байдал

Авлигын хэргийн шүүхийн шүүгч болохын тулд тусгай сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байх шаардлагатай. Түр шүүгчид ч гэсэн тусгай сургалтад суух шаардлага тавигддаг.

4. Тулгамдаж буй асуудал

Сүүлийн жилүүдэд авлигын хэргийн дагнасан шүүх нь чадварлаг хүний нөөцийн дутагдалтай байгаа нь нэлээд тулгамдсан асуудал болоод байна. Гаднаас түр шүүгч ажиллуулах нь шүүхийн шударга болон мэргэшсэн байдлыг сулруулах явдал үүсгэсэн юм. Иймд түр шүүгчийг тус улсын өнцөг булан бүрээс гэрчилгээ, батламжтай чадварлаг

мэргэжилтнүүд дотроос авлигын хэрэг бүрт өөрөөр сонгож ажиллуулах нь зүйтэй гэсэн санал гарах болсон. Өөрөөр хэлбэл түр шүүгч нь авлигын хэргийн дагнасан шүүхэд бүтэн ажлын цагаар ажиллахгүй бөгөөд өөрсдийн үндсэн ажлаа хийхийн зэрэгцээ гагцхүү шүүхийн шийдвэрлэж буй хэрэгт тусгай мэргэжилтний шаардлага үүссэн тохиолдолд тус улсын Дээд шүүхээс томилж ажиллуулах зохицуулалт хийх юм. Хэрвээ энэхүү зохицуулалт амжилттай хэрэгжвэл ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлийг өмнөхөөс бууруулах боломжтой юм.

5. Индонезийн шүүхийн туршлагаас ойлгох зүйл


- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчлийг багасгах, мэргэшсэн байдлыг нэмэгдүүлэхэд түр шүүгчийг нийт улсын хэмжээний мэргэжилтний нэрсийн жагсаалтаас хэрэг тус бүрт сонгож, томилох нь үр дүнтэй арга байх боломжтой
- Тулгамдсан асуудлыг тодорхойлох, боломжтой шийдлийг гаргахын тулд дагнасан шүүхийн үйл ажиллагааны талаар илүү их бодит мэдээлэл, харьцуулсан дүн шинжилгээ шаардлагатай
- Гагцхүү дагнасан шүүхийн үйл ажиллагаа төдийгүй хэрэг бүртгэл, мөрдөх байцаах ажиллагаа явуулдаг хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааг цогцоор нь судлах шаардлагатай байна.

Бидний хувьд хамгийн сонирхолтой загварын дагуу Хорват, Словак, Болгар гэсэн Европын гурван оронд ажилладаг. Шүүх байгуулагдсан цагаасаа 2016 он хүртэл эдгээр орнуудын авлигын талаарх ойлголтын индексийг авч үзвэл Хорват шүүхийн 9 жилийн хугацаанд 62 дахь “авлигын” байрнаасаа 55 -р байранд орсон нь маш бодитой үр дүн юм, Словак даруухан үзүүлэлттэй бөгөөд, Хорваттай харьцуулахад илүү сайн байр суурьтай байсныг анхаарах хэрэгтэй: тус улс 56 -р байрнаас 54 -р байр руу ухарчээ. Болгарын хувьд авлигатай тэмцэх шүүхийн таван жилийн хугацаанд тус улсад юу ч өөрчлөгдөөгүй бөгөөд 75-р байранд хэвээр байна. Үүний зэрэгцээ авлигатай тэмцэх шүүхүүд байгуулагдсан явдал Камерун, Бурунди, Балба, Пакистан зэрэг улс орнуудад тус нэмэр болсонгүй. Эдгээр улс орнууд авлигын гүнзгий ангал руу хэдэн арван байр сууриа ухрав. Гэгээрсэн Балба улс бүхнээс доогуур "унасан" бөгөөд энэ нь ердөө хоёрхон жилийн дотор авлигын 41 оноо авч, одоо 131 -р байранд бичигдсэн байна.

ГУРАВ. АВИЛГЫН ХЭРГИЙГ ШҮҮХЭЭС ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

2011-2020 оны хооронд Эрүүгийн хэргийн анхан, давж заалдах болон хяналтын шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн авилгын хэргийн тоон үзүүлэлт жил ирэх бүр өссөн үзүүлэлттэй, цаашид ч өсөх хандлагатай байгааг хоёрдугаар бүлэгт хийсэн тоон судалгаанаас харсан билээ. Ийнхүү авилгын хэргийн тоон үзүүлэлт жил бүр өсөн нэмэгдэж байгаатай холбогдуулан эрүүгийн хэргийн шүүхээс хянан шийдвэрлэсэн авилгын хэргийн эцсийн үр дүн болсон шүүхийн шийдвэр буюу “шийтгэх тогтоол”-ын хэрэгжилт хэр байгааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албанаас гаргасан судалгаанаас харах болно.


2018-2020 онд авилгын хэргээр эрүүгийн анхан шатны шүүхээр ял шийтгүүлсэн хүн, оногдуулсан ялын төрөл



2018-2020 онд эрүүгийн анхан шатны шүүх хуралдаанаар нийт 313 хүн ял шийтгүүлснээс 253 хүн торгох, 60 хүн хорих ял шийтгүүлсэн байна. Он тус бүрээр нь авч үзвэл, 2018 онд 30 шүүгдэгчид ял оногдуулснаас 26 шүүгдэгч буюу 86 хувьд нь торгох, 4 шүүгдэгч буюу 14 хувьд нь хорих ял, 2019 онд 85 шүүгдэгчид ял оногдуулснаас 70 шүүгдэгч буюу 82 хувьд нь торгох, 15 шүүгдэгч буюу 18 хувьд нь хорих ял, 2020 онд 198 шүүгдэгчид ял оногдуулснаас 157 шүүгдэгч буюу 79 хувьд нь торгох, 41 шүүгдэгч буюу 21 хувьд нь хорих ял тус тус оногдуулсан байна.


Эндээс үзэхэд, шүүхээс авилгын гэмт хэрэгт ял оногдуулахдаа үндсэн ялаар торгох ялыг түлхүү сонгон хэрэглэдэг болох нь нь харагдаж байна.

2021 оны эхний 3 улирлын байдлаар шүүхээс оногдуулсан ялын төрөл, хэрэгжилт



2021 оны эхний 3 улирлын байдлаар шүүхээс авилгын гэмт хэрэгт оногдуулсан хорихоос өөр төрлийн ялын хэрэгжилт торгох ял 62 хувь, эрх хасах ял 20 хувийн биелэлттэй байгаа бол авагдсан арга хэмжээний хэрэгжилт тэнссэн 46 хувь, ял хойшлуулсан 25 хувь, хугацааны өмнө тэнсэн суллагдсан 55 хувь, хөрөнгө орлого хураах 32 хувийн биелэлттэй байна.

2021 оны эхний 3 улирлын байдлаар шүүхээс авагдсан арга хэмжээний төрөл, хэрэгжилт



ДӨРӨВ. АВИЛГЫН ХЭРГИЙГ ШҮҮХЭЭС ҮР НӨЛӨӨТЭЙ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Монгол улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Төрийн үйл ажиллагаанд ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх үндсэн зарчмыг баримтлана” гэж заасны дагуу төрийн албан хаагч нь хууль, дүрэм журамд захирагдах буюу зөвхөн хуулиар олгогдсон, зөвшөөрөгдсөн эрх хэмжээний хүрээнд үйл ажиллагаа явуулах ёстой байтал албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох замаар төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг үл биелүүлэх явдал маш их байгааг бид, авилгатай тэмцэх газарт ирж буй өргөдөл, гомдол¹, шүүхээр хянан шийдвэрлэгдэж буй авилгын гэмт хэргийн тоо баримт /өсөлт/², Транспэрэнси интернешнл байгууллагаас тодорхойлсон авилгын төсөөллийн индексээр Монгол улсын сүүлийн 10-аад жилд авсан үзүүлэлт³ зэргээс харж болохоор байна.

Авилга бол эрх мэдэл бүхий цөөнх нь албан тушаалаа ашиглан хөлжиж олонхид буюу нийгэмд ноцтой хор уршиг, хохирол учруулдагараа нийгмийн хамгийн аюултай үзэгдэл учраас зайлшгүй хууль, эрх зүйн зохицуулалтыг шаарддаг. Тиймээс Монгол улс Авилгын эсрэг НҮБ-ын конвенцид 2005 онд нэгдэн орж, 2006 онд Авлигын эсрэг хуулиа шинэчлэн баталж, хуулийн дагуу 2007 оноос авилгын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авилгаас урьдчилан сэргийлэх, авилгын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, төрийн албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлгийг хянан шалгах чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан, төрийн тусгай байгууллага болох “Авилгатай тэмцэх газар”-ыг байгуулан ажиллаж байна. Авилгатай тэмцэх нь дан ганц авилгатай тэмцэх газрын бус прокурор, шүүхийн хамтын үйл ажиллагаа бөгөөд авилгатай хийх тэмцэлд Бие даасан, хараат бус, шударга шүүхийн үүрэг чухал юм.

Авилгын хэргийг шүүхээс үр нөлөөтэй хянан шийдвэрлэхтэй холбоотой дараах тулгамдсан асуудал байна. Үүнд: 1) Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдал; 2) Шүүгчийн мэргэшсэн байдал; 3) Үр нөлөөтэй мөрдөн шалгах ажиллагаа буюу үнэн бодит нотлох баримт ; 4) Шүүхийн ачаалал; 5) Хөөн хэлэлцэх хугацаа, өршөөл үзүүлэх тухай;

¹ Авилгатай тэмцэх газрын 2020 оны үйл ажиллагааны жилийн нэгдсэн тайлан [Tailan2020.pdf \(iaac.mn\)](#)

² ШЕЗ-ын Хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтэс, Авилгатай тэмцэх газрын үйл ажиллагааны тайлан <https://judcouncil.mn>, <https://iaac.mn/>

³ Транспэрэнси интернешнл байгууллагаас тодорхойлсон 2012-2020 оны авилгын төсөөллийн индексээр Монгол улс 2012 онд 36 оноотойгоор 94-р байрт, 2013 онд 38 оноотойгоор 87-р байрт, 2014 онд 39 оноотойгоор 87-р байрт, 2015 онд 39 оноотойгоор 87-р байрт, 2016 онд 38 оноотойгоор 87-р байрт, 2017 онд 36 оноотойгоор 103-р байрт, 2018 онд 37 оноотойгоор 93-р байрт, 2019 онд 35 оноотойгоор 96-р байрт, 2020 онд 35 оноотойгоор 111-р байрт орсон³ үзүүлэлтүүдээс авилгатай хийх тэмцэл тодорхой үр дүнд хүрч чадаагүй, харин ч урагшлах бус эсрэгээрээ байгааг харж болохоор байна. <http://www.iaac.mn/> [АВИЛГЫН ТӨСӨӨЛЛИЙН ИНДЕКСИЙН ҮР ДҮН](#)

4.1 Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдал

Авилгын гэмт явдалтай үр дүнтэй тэмцэхэд шударга үйл ажиллагаатай, өөрөө авилгаас бүрэн ангижирч чадсан шүүхийн үүрэг чухал нөлөөтэй болохыг Авилгын эсрэг НҮБ-ын конвенциар хүлээн зөвшөөрч улс орнуудыг шударга, авилгагүй шүүх эрх мэдлийн тогтолцоог бий болгохыг уриалсан байдаг. Бие даасан, хараат бус, шударга, авилгагүй шүүхгүйгээр авилгатай хийх тэмцэлийг хэрэгжүүлэх боломжгүй юм. Транспэрэнси интернэшнл 2011 оны тайландаа дэлхий даяар судалгаанд хамрагдсан хүмүүсийн 46 хувь нь шүүх засаглалаа авилгажсан гэж үзэж байгааг дурьдсан. Eurobarometer (2012) судалгаагаар европчуудын 32 хувь нь өөрийн улсын шүүх таслах ажиллагаанд авилга өргөн тархсан үзсэн бол Бангладешт хүн амын 88 хувь нь шүүхтэй харьцах явцад авилга өгөх болсон гэж мэдээлсэн, Перугийн хүн амын 85 хувь нь шүүх засаглалдаа итгэдэггүй гэсэн. Афганистан, Боливи, Болгар, Камбож, Хорват, Этиоп, Гүрж, Молдав, Марокка, Перу, Украин зэрэг улсад 2010-2012 онуудад шүүх байгууллага хамгийн их авилгад өртсөн төрийн байгууллагаар тодорчээ⁴. Монгол улсын хувьд ч иргэдийн шүүхэд итгэх итгэл бага байна.

Авилгын гэмт хэрэг, тэр дотроо улс төрийн, нөлөө бүхий өндөр албан тушаалтан холбогдсон, их хэмжээний үнийн дүнтэй, зохион байгуулалттай, хэд хэдэн гэмт хэргийн шинж агуулсан ээдрээ төвөгтэй хэргийг хянан шийдвэрлэхэд шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын баталгааг хангах явдал нь нэн тэргүүний тулгамдсан асуудал болоод байна.

Транспэрэнси интернэшнл, Eurobarometer судалгааны байгууллагууд Шүүх авилгад өртөхөд улс төр, бизнесийн эсвэл гэмт хэргийн бүлэглэлийн нөлөө, нийгмийн зүгээс үзүүлдэг дарамт, шахалт, шүүхийн үйл ажиллагаанд тавих иргэдийн хяналт сул, шүүгч, шүүхийн ажилтан, албан хаагчдын цалин хангамж бага, авилгаас сэргийлэх эрх зүйн баталгаат орчин бүрдээгүй, сахилга хариуцлагын тогтолцоо сул, нийгэм дэх ядуурал, улс төр нийгмийн тогтворгүй байдал зэрэг олон хүчин зүйл нөлөөлдөг талаар дурьдсан байна.

Монгол улс Үндсэн хуульд “шүүх бие даасан байх”, “шүүгч хараат бус байх”, “шүүгч зөвхөн хуульд захирагдах” гэсэн харилцан хамаарал бүхий зарчмуудыг тусгаж, эдгээрийг хангах зохион байгуулалт, эрх зүйн хийгээд улс төр – эдийн засгийн баталгаа, механизмын үндсийг тогтоож, түүний эрх зүйн орчинг бүрдүүлэх суурийг тавьж⁵, зарчмын хэрэгжилтийг хангах хүрээнд шүүхийн тухай хууль, шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, шүүхийн захиргааны тухай хуулиудаар шүүгчийн хариуцлага, ёс зүйн хэм хэмжээний асуудлыг зохицуулсан боловч төрийн улс төрийн, нөлөө бүхий өндөр албан тушаалтан холбогдсон, их хэмжээний үнийн дүнтэй авилгын хэрэгт Шүүхийн бие даасан, хараат бус байдал хангалтгүй байгааг бид шүүхээр хянан шийдвэрлэгдэж буй хэргийн төрлөөс харж болох юм. тодруулбал, шүүхээр хянан шийдвэрлэгдсэн авилгын гэмт хэргийн холбогдогч нарын ихэнх хувь нь нэр нөлөөгүй, төрийн гүйцэтгэх болон доод албан тушаалтнуудын хэрэг байх бөгөөд улс төрийн, нөлөө бүхий, өндөр үнийн дүнтэй авилгын хэрэг нь цагаатах, хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн байна.

Иймээс шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах хүрээнд **нэгдүгээрт**, Шүүгчийг томилох, дэвшүүлэх шударга тогтолцоог бүрдүүлэх **хоёрдугаарт**, Шүүгчид тооцох сахилга, хариуцлагын тогтолцоог сайжруулах **гурвдугаарт**, Авилгын хэргийг олон нийтэд нээлттэй болгох, **дөрөвдүгээрт**, Шүүгчийн цалин хангамжийг нэмэгдүүлэх, **тавдугаарт**, Шүүгч нарын мэргэжлийн ёс зүй, сахилга батыг нэмэгдүүлэх / Шүүгч өөрт нь аливаа этгээд хөндлөнгөөс нөлөөлсөн, нөлөөлхөөр оролдсон, үүрэг чиглэл өгсөн тохиолдолд шүүгч өөрийн хараат бус байдлаа сахин хамгаалан, хөндлөнгийн нөлөөнд автахгүй байх өндөр ёс зүй, сахилга баттай байж, Шүүхийн тухай хуулийн 45 дугаар

⁴ Улсын дээд шүүхийн шүүгч Ч.Хосбаяр “Авилгын эсрэг конвенц ба шүүх эрх мэдэл” илтгэл,

⁵ Ж.Амарсанаа “Ардчилсан эрх зүйн ёс”, Улаанбаатар хот, 2009 он, 14 дэх тал

зүйлийн 45.1, 45.8-д заасан нөлөөллийн мэдүүлэг, тэмдэглэл үйлдэн Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлэх, ШЕЗөвлөл нь хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж шүүгчийн хараат бус байдлыг хангах/ хэрэгтэй.

4.2 Шүүгчийн мэргэшсэн байдал

Авилгын хэрэг нь нарийн төвөгтэй санхүүгийн асуудалтай холбоотой, нарийн зохион байгуулалттай, мөнгө угаах зэрэг бусад төрлийн гэмт хэрэгтэй хамт үйлдэгдэг учраас авилгын хэргийг үр нөлөөтэй хянан шийдвэрлэхэд шүүгчийн мэргэшсэн байдлын асуудал хэргийг үр нөлөөтэй хянан шийдвэрлэхэд нөлөөлж байна. Иймээс шүүгч нарыг авилга, мөнгө угаах гэмт хэргээр мэргэшүүлэхээс гадна санхүү, нягтлан бодох, бүртгэлийн өндөр мэдлэгтэй болгох шаардлагатай байна.

4.3 Үр нөлөөтэй мөрдөн шалгах ажиллагаа буюу үнэн бодит нотлох баримт / Мөрдөн байцаагч, прокурор гадны аливаа нөлөөнд автсан байх/

Шүүх хэргийг зөвхөн хэрэгт авагдсан нотлох баримтад үндэслэн шийдвэрлэдэг тул хэргийг үр нөлөөтэй шийдвэрлэхэд мөрдөн шалгах ажиллагааны үр дүн чухал нөлөө үзүүлдэг. Хэрэв, Мөрдөн байцаагч, прокурор нь өөрөө гадны аливаа нөлөөнд автан, хэргийн нотлох баримтыг өөрчлөх, хуурамчаар бүрдүүлэх, нотлох баримтыг хангалттай цуглуулахгүй байх, хангалттай нотлох баримт цугларсанч хэргийн мөрдөн шалгах ажиллагааг удаашруулах, нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх ажиллагаанд зохих хяналт тавилгүй хэргийг шүүх рүү шилжүүлсэн тохиолдолд хичнээн шударга, авилгагүй бие даасан шүүх байсан ч хэргийг үнэн зөв шийдвэрлэх боломжгүй болно. Мөн авилгын хэргийг шүүхэд шилжүүлэхээс өмнө прокурор хэргийг хэрэгсэхгүй болгоод байвал шүүх авилгатай хийх тэмцэлд бодит үүргээ гүйцэтгэж чадахгүйд хүрнэ.

Тиймээс авилгын хэргийн мөрдөн байцаагч, прокурор хөндлөнгийн нөлөөнд автахгүй, хараат бус байх баталгаа нөхцлийг хангах, сахилга хариуцлагын тогтолцоог сайжруулахаас гадна мэдлэг, ур чадварыг нь байнга дээшлүүлэх шаардлагатай.

4.4 Шүүхийн ачаалал буюу нэг шүүгчид ногдох хэргийн тоо

Шүүхээр хэргийг шуурхай, хуулийн хугацаанд нь үр нөлөөтэй хянан шийдвэрлэхэд нэг шүүгчид оногдох хэргийн тоог зохистой хэмжээнд байлгах нь чухал нөлөөтэй. 2020 онд дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд нийт 58 шүүгч ажилласан бөгөөд нэг шүүгчид дунджаар 128.4 хэрэг ногдсон байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, шүүгчийн тоо 53,4 байснаас 4.6 хүнээр нэмэгдэж, нэг шүүгчид ногдох хэргийн тоо 116,1 байснаас 128,4 болж 16.8 хэргээр өссөн дүнтэй гарчээ. Энэхүү тоон үзүүлэлтээс харахад нэг шүүгчид ногдох хэргийн тоо зохист хэмжээнээс их байгаа бөгөөд авилгын хэргийг шүүхээр үр нөлөөтэй хянан шийдвэрлэхэд нөлөөлж байна гэж дүгнэж болохоор байна. Учир нь үйлдлийн арга нь улам нарийсч, зохион байгуулалттай үйлдэгдэж буй авилгын хэргийг үнэн зөв шийдвэрлэхэд тухайн шүүгч хэргийн материалтай бүрэн танилцах, нотлох баримтыг тал бүрээс нь бодитой үнэлэхэд цаг хугацаа шаардлагатай. Тиймээс шүүгчид ногдох хэргийн тоог зохистой хэмжээнд барих, авилгын хэргийн дагнасан шүүх байгуулах шаардлагатай гэж үзэж байна.

4.5 Хөөн хэлэлцэх хугацаа, Өршөөл үзүүлэх тухай хууль

Гэмт хэрэгт ял шийтгэл гарцаагүй байх, эрүүгийн хариуцлага буюу ял шийтгэл нь нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байх ёстой. Гэтэл нийгэмд учруулах хор аюул ихтэй авилгын хэрэгт холбогдсон этгээдийн гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон ч өршөөл үзүүлэх тухай хууль болон хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгон, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял завших

боломжийг олгож байгаа нь шүүх хэргийг үр нөлөөтэй хянан шийдвэрлэхэд тулгамдаж буй асуудлын нэг гэж үзэж байна.

Улсын дээд шүүхийн Практик судлалын хэлтсээс улсын хэмжээнд анхан шатны шүүхээр 2016-2018 онд шийдвэрлэсэн авилгын гэмт хэргээс хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон гэмт хэргийн талаарх хийсэн судалгаагаар анхан шатны шүүх авилгын гэмт хэрэгт шалгагдсан 8 хүнийг өршөөл үзүүлэх тухай хуулиар, 2 хүнийг хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна⁶.

Тиймээс авилгын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг уртасгах, өршөөл үзүүлэх хуулинд авилгын гэмт хэргийг хамруулахгүй байх шаардлагатай.



⁶ [Хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон хэргийг судалжээ \(supremecourt.mn\)](http://supremecourt.mn)

ТАВ. АВЛИГЫН ХЭРГИЙН ДАГНАСАН ШҮҮХ БАЙГУУЛСНААР БИЙ БОЛОХ ДАВУУ, СУЛ ТАЛ БОЛОН БОЛОМЖ ЭРСДЭЛ (SWOT ШИНЖИЛГЭЭ)

Авлигын хэргийн дагнасан шүүх байгуулснаар Монгол Улс дахь шүүх эрх мэдлийн тогтолцоонд дараах давуу болон сул тал, боломж ба эрсдэл үүсч болох юм. Үүнд:

S	W
<p>Давуу тал:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын хэргийг шуурхай шийдвэрлэх. Тухайн төрлийн хэргийг шийдвэрлэж буй хугацаа багасах. • Авлигын хэргийн мэргэшсэн шүүгчтэй болох. • Авлигын хэргийг шийдвэрлэж буй шүүхийн процесс ажиллагааг хялбаршуулах. 	<p>Сул тал:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын хэргийн тоон үзүүлэлтэд өөрчлөлт гарахгүй байх, буурахгүй байх. • Авлигын хэргийн дагнасан шүүх байгуулагдсанаар том бүтэц, институт бий болох. • Мөн авлигын гэмт хэргийн дагнасан шүүхийн шүүгчийн цалин хангамжийг нэмэгдүүлэх, шинэчлэн тогтоох зэргээр шүүхийн зардал өсөх.
O	T
<p>Боломж:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын хэргийн шүүхийн шийдвэрийн чанар дээшлэх. • Олон улсад авилгатай тэмцэх талаар хийж буй ажил үнэлэгдэх. Түвшин ахих. • Улс төрчид болон бусад эрх мэдэл, нөлөө бүхий этгээдийн зүй бус нөлөөлөлд автахгүй, авлигын хэргийг тэгш, шударгаар шийдвэрлэх, хараат бус, бие даасан шүүхийн тогтолцоо бий болох. 	<p>Эрсдэл:</p> <ul style="list-style-type: none"> • Шүүгчийн хараат бус байдалд халдах. Нөлөөлөлд автах. • Авлигын хэргийн дагнасан шүүхээр хэрэг нь хянагдаж байгаа иргэний мэдээлэл алдагдах, нэр төрд халдах. • Авлигын хэргийн дагнасан шүүх үр нөлөөтэй ажиллах эсэх нь тухайн шүүхэд хэрэг үүсгэх эрхтэй бусад байгууллагын (прокурор) үр нөлөөтэй ажиллагаанаас шууд хамаарах.

ЗУРГАА. АВИЛГЫН ХЭРГИЙГ ШҮҮХЭЭС ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ҮР НӨЛӨӨТЭЙ ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЭХ САНАЛ, ХУВИЛБАР)

Дагнасан шүүх хэмээх ойлголт нь дэлхийн дахинд түгээмэл үзэгдэл мөн дагнасан шүүх нь бусад ердийн шүүхтэй харьцуулахад үйл ажиллагааны үр нөлөө, бүтээмж өндөр, шуурхай процедуртай, хууль зүйн ээдрээ төвөгтэй салбарын маргаанд чанартай бөгөөд тогтвортой шүүхийн шийдвэрийг гаргах илүү боломжтой байдаг зэрэг олон давуу талтай. Авлигын хэргийн дагнасан шүүхийн хувьд эдгээр онцлог давуу тал мөн адил хамаарах хэдий ч тус төрлийн шүүхийг байгуулах хэрэгцээ, шаардлагыг дараах 3 хүчин зүйл

бүрдүүлдэг гэж үзэж болох юм. Үүнд 1. Үр нөлөө, 2. Шударга байдал, 3. Мэргэшсэн байдал хамаарна. Тус шүүхийг байгуулахад хамгийн зөв загвар, сайн туршлага болох гэсэн ойлголт байхгүй бөгөөд тухайн улс өөрийн онцлогт тохирох хамгийн тохиромжтой загварыг бий болгох нь маш олон хүчин зүйлээс хамаарах юм.

Гэхдээ энэ төрлийн шүүхийг байгуулах гэж буй ямар ч улс орон дараах 5 хүчин зүйлийг анхаарах нь зүйтэй юм.

Үүнд:


1. Шүүхийн зохион байгуулалтын хэлбэр,
2. Шүүгчдийн тоо,
3. Шүүгчийг томилох болон огцруулах процесс,
4. Шүүхийн харьяалал,
5. Прокурорын байгууллагатай холбогдох харилцан хамаарал.

Монгол Улсын хувьд авилгын хэргийг дагнан шийдвэрлэх шүүхийн 1 дүгээр хэлбэр болох нь тусдаа, бие даасан танхим, салбар шүүх, дагнасан шүүх зэрэг хэлбэрээр бус ердийн шүүхийн шүүгчийг авлигын хэргийн шүүгчээр дагнуулж, мэргэшүүлэх хэлбэр илүү зохимжтой юм шиг санагдаж байгаа юм. Энэ тохиолдолд тус шүүгчийн гаргасан шийдвэрийг давж заалдах шатны шүүх, хяналтын шатны шүүх хянах юм (Бангладеш, Кени гэх мэт улсууд хамаарна). Авлигын хэргийн дагнасан шүүхэд олон тооны шүүгчдийг томилох, нэг шүүгчид ногдох хэргийн тоог цөөн байлгах нь авлигын хэргийг шуурхай, үр нөлөөтэй шийдвэрлэхэд ач холбогдолтой. Ялангуяа энэ нь шүүхэд олон тооны авлигын хэргийг шийддэг, шүүхийн ачаалал ихтэй оронд хамааралтай байх нь ойлгомжтой юм. Монгол Улсын хувьд шүүхийн ачаалал тийм өндөр бол харагдахгүй байна. Авилгалын хэрэг дагнан шийдвэрлэх шүүгчийг сонгон шалгаруулж, томилоход тухайн хүний өмнөх намтрыг судалж, шүүгчийн шударга байдал, ёс зүйд харшлах түүх бий эсэхийг тогтоох нь шүүн таслах ажиллагааны шударга байдлыг хангах юм.

Дэлхийн улс орнуудаас хамгийн сүүлд Авилгын хэргийг дагнан шийдвэрлэх шүүхийг байгуулсан Украин улсын Шүүгчдийн дээд мэргэшлийн комиссын дарга Сергей Козяков хэлэхдээ, дэлхийн туршлага авлигатай тэмцэх шүүхийн үр дүнтэй гэдгийг батлаагүй гэж Брюссель хотод "Укринформ" - д өгсөн ярилцлагдаа дурьджээ. "Авлигатай тэмцэх шүүхийн талаар ярихад одоогоор надад маш их эргэлзээ төрж байна. Бусад улс оронд авлигатай тэмцэх шүүхүүд байдгийг харьцуулсан дүн шинжилгээгээр (АНУ-ын АИДЕД бэлтгэсэн) харуулсан судалгаанд үндэслэн би тухайн дүгнэлтийг гаргаж байгаа бөгөөд би хувьдаа Авлигатай тэмцэх шүүхийн салбарт амжилттай хэрэгжүүлж буй дэлхийн практикийг олж харахгүй байна" хэмээсэн. Мөн зарим судлаачдын зүгээс Европын гурван улсад л авлигын эсрэг шүүх байдаг ба үүнээс Словакийн шүүхийн туршлага сөрөг үр дүнтэй байна. Авлигатай тэмцэх шүүх байдаг дэлхийн бусад улс орнуудын дунд ч Алжир, Пакистан, Индонезийн үр дүн ч мөн сайнгүй байдаг бөгөөд Украин улсын хувьд авлигатай тэмцэх шүүх байгуулах нь ОУВС-гийн өмнө Украины хүлээсэн үүргийн нэг тул гарцаагүй байдалд байгуулсан мэт харагдаж байгаа юм.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

1. Монгол улсын Үндсэн хууль
2. Авилгын эсрэг хууль
3. Шүүхийн тухай хууль
4. Эрүүгийн хууль
5. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
6. Авилгын эсрэг НҮБ-ын конвенц 2005 он
7. Ж.Амарсанаа “Ардчилсан эрх зүйн ёс”, Улаанбаатар хот, 2009 он,
8. Авилгатай тэмцэх газар, “Шударга байдал ба олон нийтийн итгэл” хуулийн байгууллагуудын нэгдсэн зөвлөгөөн, 2020 он.
9. Авилгатай тэмцэх газрын 2020 оны үйл ажиллагааны жилийн нэгдсэн тайлан [Tailan2020.pdf \(iaac.mn\)](#)
10. <http://www.iaac.mn/> **АВЛИГЫН ТӨСӨӨЛЛИЙН ИНДЕКСИЙН ҮР ДҮН**
11. [Хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон хэргийг судалжээ \(supremecourt.mn\)](#)
12. Matthew Cstephenson Professor of Law, Harvard, Sofie Aschutte Senior advisor “Авлигын хэргийн дагнасан шүүхийн харьцуулсан судалгаа”, 2016 он
13. Matthew Cstephenson Professor of Law, Harvard “Авлигын хэргийн дагнасан шүүх: Словак”, 2016 он
14. Matthew Cstephenson Professor of Law, Harvard, “Авлигын хэргийн дагнасан шүүх: Филиппин”, 2016 он
15. Matthew Cstephenson Professor of Law, Harvard, “Авлигын хэргийн дагнасан шүүх: Индонез”, 2016 он



Судалгааг гаргасан

Судлаач багш..... Б.Хонгорзул
Судлаач багш..... Г.Номин
Социологич-судлаач.....Б.Доржпагма

Судалгааг хянасан

СМСТөвийн захирал.....Б.Айбек